



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/425

Мөрөн

Зардал батлах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын 2016 оны 03, аймгийн ИТХ-ын 2017 оны 01 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 81 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн үндэсний их баяр наадамд амжилт гаргасан бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай шагналын хэмжээг 1 дүгээр хавсралтаар, наадмын бэлтгэл ажиллагааг хангахтай холбогдон гарах зардлыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардлын 10,000,0 /Арван сая төгрөг/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас, 30,000,0 /гучин сая/ төгрөгийг орон нутгийн төсөвт тусгагдсан наадмын бэлтгэл ажиллагааны зардлаас, эрлийз морьд уралдуулах, шагайн харваа, хүүхдийн бөх, хүүхдийн сурын харваа зохион байгуулахтай холбогдон гарах 4165,0 /дөрвөн сая нэг зуун жаран таван мянга/ төгрөгийг аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус санхүүжүүлэхийг аймгийн ЗДТГ-ын дарга Х.Ган Очир, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувд нарт зөвшөөрсүгэй.

3. Наадмын үед замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгсэлд тусгай зөвшөөрөл олгож, зөвшөөрлийн хураамжийн орлогыг наадмын үеийн хэв журмын аюулгүй байдлыг хангахад зарцуулж, бүртгэн тайлагнахыг Цагдаагийн газрын дарга, /дэд хурандаа Ц.Адьяацэрэнд/-д үүрэг болгосугай.

4. Наадам зохион байгуулах комиссын дарга А.Эрдэнэбаатарт ДААЛГАХ нь:

1. Наадмын бэлтгэл ажил зохион байгуулалтанд аймгийн мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулж, чиг үүрэг өгсөн үүрэг даалгаврын хэрхэн хэрэгжүүлж байгааг тухай бүрд нь танилцуулж байх.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж төсвийн гүйцэтгэлийг Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнах.

ДАРГА



Л.ГАНБОЛД